

БНСУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

Т.Намжил*
Д.Батцэцэг*

Эдийн засгийн өсөлт нь цэвэр бүтээгдэхүүний хэмжээний өсөлтөд л хязгаарлагддаггүй, техникийн дэвшил, ард түмний хандлага ойлголтын өөрчлөлттэй ч холбоотой байдаг байна. Үүнийг тодруулбал:

-Үйлдвэрлэлийн хүчин чадлын тасралтгүй өсөлт. Энэ нь илүү олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байж, үйлчилгээгээр ард түмнээ тасралтгүйгээр хангаж чадах үйлдвэрлэлийн хүчин чадлын тэлэлт юм.

-Үл тасалдах дагалдан техникийн дэвшил гарч ирэх ёстой. Шинэ техник нь шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг үр дүнтэй болгож өгдөг төдийгүй үйлдвэрлэлийн бүтээмжийг сайжруулснаар илүү олон бүтээгдэхүүн, үйлчилгээг ард түмэндээ нийлүүлэх боломжтой болдог байна.

-Ард түмний ухамсарын түвшин дээшилснээр амьдралын хэв маяг, эдийн засгийн тогтолцоо болон ойлголтын өөрчлөлт нь эдийн засгийн өсөлтийг урагшлуулах нэгэн хандлага болж байгаа явдал юм.

Солонгосын эдийн засгийн нөлөө, ард түмний амьдралын өөрчлөлт

1980-аад он болоход Солонгос улс бүтээгдэхүүний үнийг тогтворжуулж, олон улсын орлого зарлагын алдагдалаа багасгаснаар эдийн засгийн өсөлтийн дундаж хэмжээ жилд 8%-д хүрсэн бөгөөд хөдөлмөрийн хүчийг ихээр бий болгож, нөгөөтэйгүүр ард түмний амьдралын чанарын өсөлт бий болж амьдралын түвшинг дээшлүүлж байна. Эдийн засгийн өсөлт нь Солонгосын ард түмний амьдралд ямар өөрчлөлт авчирсныг үзлгээе.

Эдийн засгийн өсөлт нь ард түмний материаллаг амьдралыг тоо, хэмжээний төдийгүй, чанарын хувьд хангаж өгдөг. 1960 он хүртэл Солонгосын нэг хүнд оногдох орлого 100\$ орчим байсан, хоцрогдсон буурай орон гэдэг муу нэрнээсээ салж чалаагүй байсан үе.

Дэлхийн бусад буурай орнуудын нэгэн адил ядуу тарчиг байдал илүү хурдасаж, өлсөж үхэх явдал гарч байсан бөгөөд гудамжинд гуйлгачин хүмүүс их болсон. Хувцас хунар, хоол хүнс, гэр орон гээд

*Т.Намжил - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D)

*Д.Батцэцэг - "Скайтель" худалдааны төвийн менежер

бүх зүйлээр дутагдаж гачигдаж байв. Гэтэл өнөө үед үйлдвэрлэлийн бүтээгдхүүний тоо, төрөл олширч хангалттай болон 1992 оны тогтмол үнээр ҮНБ (үндэсний нийт бүтээгдхүүн) 1248 тэрбум 510 сая вон болсон ба үүнийг дагаж нэг хүнд оногдох ҮНБ 1992 онд ойролцоогоор 7500\$-д хүрч байлаа. Энэ нь үнэхээр гайхалтай дэвшил байлаа. 1960 онд идэх ч зүйл байхгүй өлсөж үхэхгүйн тулд өвсний үндэс түүж иддэг хүмүүс ч байсан бөгөөд өнөө үед энэ нь нэгэнт түүх болжээ. Нэг хүнд оногдох ҮНБ 7500\$-ыг давахад хүмүүс үхрийн мах, гахайн мах зэрэг махан бүтээгдхүүн, амт чанар сайтай хүнсний ногоог идэж хэрэглэх болсон ба ард түмний сонирхол, чөлөөт цагаа өнгөрүүлэх зүйлүүд их болсон. Жишээ нь: Урьд хэн нэг нь хурим найр хийхэд идэх л гэж ирдэг хүмүүс их байсан бөгөөд өнөө үед идэх гэж хуримын ёслолд ирэхээ больсон аж.

1960-аад онд Солонгос улс ядуу байх үед бусдын гэрт будаа чанасан усыг уудаг байсан бөгөөд савны ёроол дахь будааны үлдэгдлийг идэхийн тулд том савтай усыг бүгдийг нь уух ч тохиолдол байсан гэдэг. Одоо үед олон төрлийн ундаа гарч будааны усыг уух хүн бараг үгүй болжээ.

Энэ нь Солонгосын ард түмний амьдралын түвшин тэр хэмжээгээр дээшилснийг харуулж байна. Орлогын түвшин дээшилж, ууланд авирах, загасчлах, шавар эдлэл хийх, цэцэг тарих, бийрийн бичлэг ба зураг, төрөл бүрийн спорт, аялал зэрэг хүмүүсийн сонирхол болсон чөлөөт цагаа өнгөрүүлэх зүйлүүд их болсон ба үүнээс шалтгаалан өмнө нь харах байтугай сонсоо ч үгүй бүтээгдхүүнүүд үйлдвэрлэн гаргаж байна.

Эдийн засгийн өсөлт нь ард түмнийг илүү боловсон, дээд зэргийн болгон төгөлдөржүүлж байна. Орлогын түвшний өсөлт болон хүмүүсийн мэдлэг боловсролд анхаарлаа хандуулснаар ард түмний боловсролын түвшин ихээхэн дээшилж байна. Бүрэн дунд боловсролтой хүний тоо ихээхэн өссөн бөгөөд цаашид ч нэмэгдсээр байх төлөвтэй. Жил бүр олон мянган хүн их, дээд сургуульд элсэн орж байна. Үүнтэй зэрэгцүүлэн их, дээд сургуулиуд ч ихээр байгуулагдаж байгаа бөгөөд Соёл Боловсролын Яам нь их, дээд сургуулийн сургалтын түвшинг дээшлүүлэхэд ихээхэн анхаарах боллоо.

Ихэнх хүмүүс гадаадад сургуульд сурах болвол тэр тосгоньхон бөөн хөл шуугиан болдог байжээ. Хүмүүсийн орлогын түвшин доогуур байснаас үр хүүхдээ сургах нь хэцүү байлаа. Гэтэл өнөө үед их, дээд сургуулийн боловсрол өргөн болсон бөгөөд их, дээд сургуульд орно гэдэг сонирхолтой зүйл байхаа больсон. Соёлын түвшин ч ихээхэн дээшилжээ. 1960 оны үед хөдөө тосгонд хөргөгч, өнгөт зурагт, телефон

зэргийг хэрэглэх айл байгаагүй. Гэтэл өнөө үед тариачид хөргөгч, өнгөт телевизор, телефон, угаалгын машин зэргийг өргөн хэрэглэх болжээ. Урьд цагт тосгонд нэг радиотой, тэр радиог сонсох гэж олон хүн цуглардаг байв..

Өнөө үед телевизийн олон сувгийг алсын зайны удирдлагатай телевизороор үзэж байна. Мөн жил бүр сая гаруй гадаадын хүмүүс Солонгост ирж, олон зуун мянган Солонгос иргэд дэлхийн олон улс орон руу айлчилж байгаагийн зэрэгцээ гадаадын шинэ соёл, технологи нэвтрэх боломж ихсэж байна. Мөн салбар болгонд нэрээ дэлхийд гаргаж буй мэргэжилтнүүд гарч ирж байгаа нь Солонгос хүний чадварлаг байдлыг дэлхий дахинд таниулж байна. Үүний нэгэн адил эдийн засгийн өсөлт нь ард түмний мэдлэг чадвар болон соёлын түвшинг дээшлүүлж, мэдлэг чадвар бүхий боловсон хүчнүүд бий болж байна.

Эдийн засгийн өсөлт нь ажилд орох боломжийг ихэсгэж, ажилгүйдлийг багасгадаг. Эдийн засгийн өсөлтөөр ажилд орох боломж ихэсвэл хүн өөрийн хүссэн ажилд хүчээ дайчлан ажиллаж, улмаар үйлдвэрлэлийн бүтээмж ихэсгэх талтай. 1960-аад онд газар тариалан нь үндэсний хөдөлгөгч гол хүчин зүйл болж байсан бөгөөд газар тариалан эрхлэхтэй холбогдсон биеийн хөдөлмөр эрхэлж байлаа. Жишээ нь: 1960 онд Сөүлийн буудлын өмнө үүрэгч юм уу ачигч хүн аливаа ачаа тээшийг зөөж өгдөг байсан. Гэтэл өнөө үед үүний оронд тусгай машин хэрэглэх болсон. Эдийн засгийн өсөлтөөр газар тариалангийн бус ажил, мөн биеийн бус хөдөлмөр ч ихээр бий болж, ажил нь ачаалал багатай болжээ. Газар тариалан ч гэсэн өнөө үед машин техник ашиглах болж өмнөх шигээ хэцүү биш болсон. Өмнө нь ажил хийж цалин авч ашиг олохоосоо илүү хохирол амсах нь харьцангуй их байсан бол эдийн засгийн өсөлтийн ачаар тийм тохиолдол багассаар байна. Мөн эдийн засгийн өсөлт нь ажилчдын амьдралд чанарын өсөлтийг авчирчээ. Нэг жишээ авч үзье. Өмнө нь хөдөө тосгодын ойролцоох уулс мод ч үгүй нүцгэн уулс л байдаг байжээ. Түүний шалтгаан нь молыг түлшний зорилгоор хэрэглэх гэж хайр гамгүй хандсанаас болсонтой холбож байна. Тэгвэл өнөөдөр хөдөө тосгодын ууланд ой шугуй нь өтгөн болсон. Энэ учрыг хөдөөний тариачнаас асуухад уулын модыг түлээ болгож хэрэглэхээ больсон юм гэж хариулж байна. Айл болгон шахмал түлш хэрэглэж байгаа учир мод огтлох шаардлагагүй болсон. Тэгвэл шахмал түлш бэлтгэхэд үнэ өртөг нь их биш үү гэж асуулаа. Одоо үед мод бэлтгэж түүнийгээ зөөвөрлөж авчирах нь хэцүү төвөгтэйгээс гадна шахмал түлш хэрэглэх чадалтай болжээ. Өмнөх шиг идэх хоолоо залгуулахад хэцүү үед бол шахмал түлш гэдэг нь бөөн дарамт болох байлаа. Өнөө үед хүмүүст шахмал түлшний үнэ нь дарамт

биш юм. Энэ юуг харуулж байна вэ?

- тариачдын орлогын түвшин эрс нэмэгдэж байгаа,

- уул руу гараад мод бэлтгэвэл мөнгө хэмнэж болох боловч тухайн хүний олох ашгаас түлээ бэлтгэх үед гарах элдэв хүндрэл, саадыг давж гарах учраас шахмал түлш хэрэглэж байна.

Энэ нь Солонгос улсын эдийн засгийн өсөлтөөр ажилчил болон ард түмний амьдрал чанарын хувьд эрс дээшилснийг харуулж байна.

Эдийн засгийн өсөлтийн ачаар ард түмэнд илүү гэрэл гэгээтэй, цэвэр цэмцгэр ая тухтай амьдрах сайхан төлөв бий болжээ.

Эдийн засгийн өсөлт нь ард түмний орлогын түвшинг эрс дээшлүүлж, хүн ардын эрүүл мэндийг сайжруулснаар хүмүүсийн дундаж наслалт уртассан байна. Эдийн засгийн өсөлттэй уялдан эрүүл ахуйн техник хөгжиж, төрөл бүрийн халдварт өвчний хэмжээ багассан. Жишээ нь: өмнө нь цусны өвчтэй байвал уушгины өвчний нэгэн адил хорионд байх болдог байв. Гэтэл өнөөдөр энэ өвчнийг амархан эмчилж чаддаг болсон аж. Солонгос улсын иргэдийн дундаж наслалт 1960 онд 55 нас байгаад хэдийнэ дал болж өссөн аж. Гэвч хөгжилтэй орнуудтай харьцуулахад 3-4 нас доогуур үзүүлэлтэй байна.

Солонгосын эдийн засгийн өсөлтийн онцлог

Солонгосын эдийн засгийн өсөлтийн онцлог юунд байв?

Солонгосын эдийн засгийн өсөлт нь хурдацтай өсөлт байлаа.

Солонгосын эдийн засгийн өсөлтийн хэмжээг ажиглавал 2 дахь удаагийн нефтийн хямрал болсон 1980 оныг эс тооцвол 1963 оноос хурдацтай өсөлтөнд шилжсэн. Ялангуяа олон улсын 2 дахь удаагийн түүхий эдийн хямрал болсон 1980 оныг эс тооцвол 1969 оноос хойш Солонгосын эдийн засаг дэлхийн түүхэнд байгаагүйгээр өссөн юм. Өнөө үеийн эдийн засгийн нөхцөл байдал болон Солонгос улсын үндсэн хүчин чадлыг нэгтгэн дүгнэж үзвэл ойрын ирээдүйд ч гэсэн тогтвортой хөгжлийг хадгалж чадахаар харагдаж байна.

Солонгосын хурдацтай өсөлтөнд эдийн засгийн хөгжлийн 5 жилийн төлөвлөгөө ихээхэн нөлөөлсөн гэж үзэж болно. 1960-аад оны эхэн үед хөгжлийн стратегийг сонгох үед хилийн чанад руу чиглэсэн эдийн засгийн хөгжлийг үндэс болгожээ. Тэр үеэс үндсэн стратеги өөрчлөгдсөнгүй. 1970-аад оноос Солонгос нь аж үйлдвэрийн бүтцээ бэхжүүлэхийн тулд химийн хүнд үйлдвэр лүү анхаарлаа хандуулсан байна. Хүнд үйлдвэрийн хөгжлийг даган хагас боловсруулсан бүтээгдхүүнийг бие даан үйлдвэрлэх болжээ. Энэхүү эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөнд орсноор эдийн засгийн өсөлтийн жилийн дундаж

хэмжээ нь, 1-р таван жилийн төлөвлөгөөний хугацаанд (1962-1966) 7.7% байсан бол Ү таван жилийн төлөвлөгөөний хугацаанд 8,6% болсон байна.

Солонгосын эдийн засгийн өсөлтийн хэмжээ жил бүр өөрчлөгдөж байсан ба тухайн жилийн хувийг өмнөх жилтэй харьцуулахад тус бүрдээ ялгаатай байна.

Гол шалтгаан нь Солонгосын эдийн засгийн цар хүрээ хөгжингүй орнуудынхтай харьцуулж бага төдийгүй эдийн засагт гадаадын нөлөөлөл их байгаа зэргээс болж байна.

Солонгосын эдийн засгийн өсөлтийн хүчин зүйл

Эдийн засгийн өсөлтийн хүчин зүйл нь тухайн улс орон, цаг үеэсээ хамааран ялгаатай байдаг байж болох юм. Гэвч бүх улс орон үндэстэн бүх үед нэг дор үйлчилдэг шалтгааныг дараах 4 янзаар ангилж болох юм. Үүнийг Солонгосын эдийн засгийн хөгжлийн 4 үндсэн хүчин зүйл гэж бичиж байна. 1. Боловсон хүчин 2. Хөрөнгө 3. Техник 4. байгалийн нөөц баялаг.

Солонгос улс эдийн засгийн өндөр хөгжилд амжилтанд хүрсэн шалтгааныг судлаж эхэлсэн.

Үүнд анхааруултай нь Солонгосын боловсролын түвшин өндөр байгаатай холбоотой.. Энэ нь үйлдвэрлэлийн чанарыг дээшлүүлэх, шинээр үйлдвэрлэлийн бүтээмж өсгөх, техникийн шинэчлэл болон шинэ технологи нэвтрүүлэхэд ач холбогдлоо өгчээ. Хүмүүсийн боловсролын түвшин өндөр байснаар:

1. Хөдөлмөрийн бүтээмж дээшилсэн
2. Техник шинэчлэгдэж ингэснээр эдийн засгийн өсөлт улам эрчимтэй болж байна.

Солонгосын эдийн засгийн өсөлтийн хүчин зүйлсийн онцлог нь гол хөгжингүй орнуудтай харьцуулахад хөдөлмөрийн нийлүүлэлтэй холбоотой тоо хэмжээ их байгаа бөгөөд нөгөө талаар техникийн дэвшлийн эзлэх хувь хэмжээ бага байгаа юм. Энэ нь улсын эдийн засгийн өмнөх өсөлт нь хөдөлмөр нийлүүлэлт, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжилд тулгуурлаж байсантай холбоотой юм.

Эдийн засгийн хүн амын өсөлтийн хэмжээ нь үргэлжилж хөдөлмөр эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ үзүүлсэн юм.

Солонгос улс газар нутгаа зөв зохистой, ашиглах нь эдийн засгийн хөгжилтөнд ихээхэн ач холбогдолтой. Мөн хязгаарлагдмал нөөцийг зүй зохистой ашигласнаар эдийн засгийн өсөлтөнд хувь нэмэр үзүүлнэ гэж үздэг байна.